

<https://doi.org/10.65816/jsds.2025.04.018>

Дэлхийн II дайны төгсгөл: Чөлөөлөх дайны 80 жилийн дараах сургамж

Ш.Паламдорж

*Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн
Цэргийн урлаг судлалын төв*

ABSTRACT

The losses, disasters, and suffering of World War II are the lessons of war. In this article, the researcher expresses his personal opinion on the importance of understanding the consequences and significance of war in a broader context and the fact that leaders of some countries have forgotten this, leading to wars in Gaza and Ukraine.

Keywords: *The end of World War II: Lessons of the War of Liberation; Who Forgot the Lessons of War; The War in Israel and Ukraine; Lessons in the Wider Sphere of War.*

ОРШИЛ

Бид энэ оны 8 дугаар сарын сүүлчээр Дэлхийн II дайны төгсгөл: Чөлөөлөх дайны ялалтын 80 жилийн ойд зориулан эрдэм шинжилгээний олон улсын хурал хийлээ. Хурлын зорилго нь судлаачдын хувьд, түүхээ тодруулан судалж, сургамжийг нь шинээр харахад оршсон хэмээн үзэж байна. 1945 оны намар Алс дорнодод явагдсан чөлөөлөх дайн бол энэ нутагт эхэлсэн дэлхийн II дайны үргэлжлэл, түүний төгсгөл болсон түүхэн үйл явдал юм.

Дэлхийн II дайны төгсгөл: Чөлөөлөх дайны дараах сургамж олон талтай, дэлхийн II дайн 1945 оны 9 дүгээр сарын 2-нд албан ёсоор дууссан хэдий ч түүний үр дагаврын хохирол нөхөж баршгүй их юм. Энэ дайны үр дагаврын улмаас 70 гаруй сая хүний амь үрэгдэж, тэдгээрийн ихэнх нь энгийн иргэд байсан бөгөөд 10 000 гаруй хот, суурин сүйтгэгдэж, дэлхийн эдийн засаг 4 их наяд гаруй ам.долларын хохирол амссан сургамжийг үлдээсэн. Дэлхийн II дайнд 61 улс орон, дэлхийн хүн амын 80 орчим хувь оролцож, 110 сая гаруй хүн цэргийн албанд татагдсан тоо баримт бий.

Монголчуудын хувьд, Ардын цэргээ анх удаа дайчилгаагаар¹ өргөтгөн зохион байгуулж, 759,3 мянган хүн амтай² байж, 41168 мянган цэрэгтэй³ болж түүнийгээ чөлөөлөх дайнд оролцуулжээ. Таван өрх гэр тутмаас нэг хүн цэрэгт татагджээ. Японы Квантуны армийн эсрэг Монгол, Зөвлөлтийн цэргийн явуулсан байлдааны

¹ МУУТА.ТБА. Х-1, Д-3, ХН-401.х12-13;

² Үндэсний статистикийн хороо. Монгол Улсын хүн ам – 1923. УБ., 2024 он. Т.4;

³ Д. Гомбосүрэн. Монгол Ардын Хувьсгалт Цэргийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулсан нь. Чөлөөлөх дайны 55 жилийн ойн олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. 2000 он;

ажиллагаанд Монгол ардын хувьсгалт цэрэг (МАХЦ)-ийн 5, 6, 7, 8 дугаар морьт дивиз, 7 дугаар моторжуулсан хуягт бригад, 3 дугаар их бууны тусгай хороо, 3 дугаар танкийн тусгай хороо, холбооны тусгай хороо, 9 дүгээр бэлтгэл морьт хороо, нисэх дивиз зэрэг нэгтгэл ангиуд, ар талын ангиуд, хилийн цэргийн 8 отряд, Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядын нийт 24000 гаруй дайчид оролцсон байна. Харин нарийвчилсан тоо баримтыг харвал, морьт механикжуулсан бүлгийн бүрэлдэхүүнд 21 000 гаруй монгол цэрэг байлдаанд оролцжээ. МАХЦ-ээс алагдсан, сураггүй алга болсон хохирол нийт 80-аад (122) хүн болжээ⁴. Эд материалын хувьд 195 сая төгрөгийн хохирол (тухайн үеийн ханшаар)-ыг хүлээсэн байна.

Энэ бүх гай гамшиг, зовлонгоор мартагдахааргүй сургамжийг үлдээсэн ч дэлхийн зарим улс орнуудын удирдлага мартах тийшээ болжээ.

Нэг. Дайны мартахааргүй сургамжийг мартсан учир өнөөдөр дайн үргэлжилж байна:

Яагаад өнөөдөр Газын зурвасад, Украинд дайн явагдаж, түүнийг зогсоох талаар олон улс орны төр засгийн тэргүүн нар хичээл зүтгэл гаргахгүй байна вэ? Дайн гарах шалтгаан үүсэх нь хүний нийгмийн зүй тогтолт үзэгдэл хэдий ч, соёлт нийгмийн өнөө үед түүнийг ухаалгаар зохицуулах тал нь давамгайлж байгааг хэлэх нь зөв байх. Дэлхий дахинаа үндэстэн, улс гэх субъектийн язгуур эрх ашиг, сонирхол гэж юу юунаас үнэтэй нэгэн зүйл байдаг. Тодруулж хэлбэл, хамгийн эхнийх нь улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрх байдлыг хамгаалах, хоёр дахь нь хэл, соёлоо хадгалах, хамгаалах. Үүнд нь аюул занал тулгарахад түүнийг шийдвэрлэх тайван арга зам нь мухардалд орох, хадгалах, хамгаалахын төлөөх гэрээ хэлэлцээрийг үргэлжлүүлэх нь цаг хугацаа алдаж язгуур эрх ашиг, сонирхол нь алдагдахад хүрэх үед эцсийн аргыг ашиглахад хүрдэг.

Шинэ дайн үүсэх нь өнгөрсөн үеийн дайны үр дагавар, шийдвэр байх нь түгээмэл. Яг л энэ байдал Газын зурвасад ч, Украинд ч бий болсныг санууштай.

Израйл улсыг дэлхийн II дайны дараа 1947 онд НҮБ-аас Палестиныг Араб, Еврей гэсэн хоёр улс болгон хуваах асуудлаар явуулсан санал хураалтын дүнгээр Иерусалим нийслэлтэй сионист улс байгуулагдсан түүхтэй. 1947 оны 11дүгээр сар гэхэд НҮБ-ын гишүүн улс 58 байв. Нааштай шийдвэр гаргахын тулд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн гишүүдийн гуравны хоёр нь “зөвшөөрсөн” санал өгөх ёстой байв. 1947 оны 11 дүгээр сарын 26-нд урьдчилсан санал хураалт явагдахад Израйлыг 25 нь дэмжсэн, 13 нь эсрэг, 17 нь түдгэлзсэн, Филиппин, Парагвай, Тайландад оролцоогүй ажээ. Дахин санал хураалтыг 1947 оны 11дүгээр сарын 29-нд явуулахад, 33 нь дэмжсэн, 13 нь эсэргүүцсэн, 10 нь түдгэлзсэн, Тайландад оролцоогүй байна. Ийнхүү улаан шугамыг давж Израйл байгуулагдсан шийдвэр гарчээ. Үүнд Сталины оруулсан хувь нэмэр нь БНМАУ-ын статус-кво-той зүйрлэшгүй их юм. Энэхүү шийдвэрийг Палестины арабууд үл зөвшөөрч Араб-Израйлын дайн гарч, түүнд Израйл ялалт байгуулснаар энэ улсын хил хязгаарыг НҮБ-ын хуваах төлөвлөгөөнд зааснаас ч илүүгээр сунгажээ. Үүнээс хойш Израйл, Арабын улсууд хоорондын

⁴ 78 - 80-аад хүн дайнд нас барсан, сураггүй болсон буюу шархадсан байна. (Г.Мягмарсамбуу), 122 хүн амь насаа алдсан гэж Ю.Цэдэнбал даргын хүн хүчний хохирлыг гаргасан тоо;

дайн тасралттай ч 80 шахам жил үргэлжилж байгаа бөгөөд түүний тайлбарыг хийнэ гэвэл, миний өгүүллийн зорилго хазайхад хүрэх тул үүгээр хязгаарлая.

Украины хувьд, Оросын эзэнт гүрэн задран унасны дараа Украины Бүгд Найрамдах Ард Улс (БНУАУ)-ыг Харьков хотод 1918 оны 1дүгээр сарын 9 (22)-нд, улмаар 1918 оны 3дугаар сарын 17-19-нд тэрээр Украиныг Зөвлөлтийн тусгаар тогтносон бүгд найрамдах улс хэмээн тунхаглав. 1934 онд Украины нийслэлийг Харьковоос Киевт шилжүүлсэн байна.

Москва дахь төрийн эргэлт хийх гэсэн хуйвалдаан, хямралын дараа, 1991 оны 8дугаар сарын 24-ний өдөр Украины Дээд зөвлөл тусгаар тогтнолоо тунхаглав. 1991 оны 12дугаар сарын 8-нд ЗХУ-ыг үүсгэн байгуулсан гурван бүгд найрамдах улсын тэргүүн Л. М.Кравчук (Украин), Б.Н.Ельцин (Орос), С.С.Шушкевич (Беларусь) нар Беловежийн хэлэлцээрт гарын үсэг зурж, ЗХУ-ыг дуусгавар болгож, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийг байгуулав.

ЗСБНХУ задран унасны дараагаар Украин, Оросын хооронд тусгаар тогтнолын зэрэгтэй холбоотой хурцадмал байдал үүсэж эхэлсэн байна. ЗСБНХУ задран унасны дараа үүссэн хоёр улсын хоорондын хурцадмал байдал 1990-ээд оны турш үргэлжилж, зөрчилдөөн, 2014 онд хязгаарлагдмал цэргийн сөргөлдөөний нээлттэй мөргөлдөөн болон 2022 онд Дэлхийн II дайнаас хойших Европ дахь хамгийн том дайн болж хувираад байна. Энэ дайн ЗХУ-ыг дуусгавар болгосон, тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийг байгуулсан шийдвэрийн шууд үр дагавар юм.

Украин дахь дайныг ОХУ эхлүүлсэн гэж барууныхан үздэг. Үнэн хэрэг дээрээ энэ нь эсрэгээрээ юм. Баримт үйл явдлын мөрийг мөшгөвөл, Украинд “Майдан” гэх 2004 оны улбар шар хувьсгал, 2013-2014 оны Евромайдан гэх хоёр томоохон эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөснөөс ил тод болсон үйл явдлаас эхэлдэг. Энэ хоёр үйл явдал Киевийн төв талбай “Майдан Незалежности” гэдэг талбай дээрээ болж, хоёулаа тухайн үеийнхээ засгийн газрын эсрэг, Украины Европын интеграцийг дэмжих зорилготой байв. **Нэгд**, улбар шар хувьсгал (2004): Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа нэр дэвшигч Виктор Ющенкогийн дэмжигчид засгийн газрыг сонгуулийн дүнг луйвардсан гэж буруутгаснаар эсэргүүцлийн жагсаал эхэлсэн; **Хоёрт**, Евромайдан (2013-2014): Виктор Януковичийн засгийн газрыг ЕХ-той Холбооны гэрээнд гарын үсэг зурахаас татгалзсаныг эсэргүүцэж эхэлсэн түүхтэй. Эсэргүүцэл нь олон нийтийн мөргөлдөөн болон даамжирч, эцэст нь эрх мэдлийг сольж, Януковичийг зугтахад хүргэсэн. Эдгээр үйл явдлуудыг хожим хувьсгал гэж нэрлэх болсон; **Гуравт**, ЕХ болон НАТО-гийн улсууд Украйныг өөрт элсүүлэх гэсэн сайхан амлалт доор ОХУ-ын хилд өөрийн цэргийн хүчийн байршуулж, стратегийн давуутай байдлыг болгохыг зорьж байлаа.

Яагаад ОХУ, Украинд цэргийн тусгай ажиллагаа явуулах болсон үндэслэл олон учир холбогдолтой гэж үзэж байна. Өнөөгийн энэ дайн Беловежийн хэлэлцээрт гарын үсэг зурж, ЗХУ-ыг дуусгавар болгосон шийдвэрийн үр дагавар мөн болохыг дахин хэлье. Хэд хэдэн үндэслэл байдаг. Үүнд: **нэгд**, ОХУ-ын хил орчмын аюулгүй байдлыг алдагдуулах нөхцөлийг НАТО-гийн зүгээс бий болгож эхэлсэн; **хоёрт**, Украинд орос хэл, соёлтой иргэдийн эсрэг ялган гадуурхах

үзэл дэлгэрч, түүнийг Украины төр засгийн удирдлага зохион байгуулж, хууль тогтоомжоор баталгаажуулсан; *гуравт*, энэ байдал улам бүр идэвхжиж, иргэний дайны хэлбэрт шилжиж, орос хэл, соёлтой иргэдийн амь насыг олноор бүрэлгэж эхэлсэн байна. Үнэн чанартаа Украинд орос хэл, соёлтой иргэдийн эсрэг иргэний дайныг эхлүүлсэн юм.

Украин дахь дайныг барууныхан өөрийн “төлөөлөл” болсон Украины үндсэрхэг үзэл сурталт төр засгаар дамжуулан эхлүүлсэн болох нь дайн эхлэхээс өмнөх болон өнөөгийн үйл явдлууд нотлон харуулсаар байгаа юм. Украин дахь өнөөгийн дайн “төлөөллийн дайн”-ы хэлбэртэй болжээ.

ОХУ нь Украин дахь орос хэл, соёлоо, иргэдээ хамгаалахын тулд цэргийн тусгай ажиллагааг эхлүүлсэн болохыг дээрх тайлбараас харагдаж байгаа юм.

Газын зурвасад, Украин дахь дайны шалтгаан нь өмнөх Дэлхийн II дайны үр дагавар, улс төрийн шийдвэрүүдээс эхтэй бөгөөд эдгээр дайныг эхлүүлэх шалтгааны мөн чанар нь улс орны тусгаар тогтнолоо олох, нутаг дэвсгэрээ хамгаалах, аюулгүй байдлаа хангах, хэл, соёлоо, иргэдээ хамгаалахад оршиж байна.

Хоёр. Дайны сургамжийг хэн мартаад байна:

Дайныг мартаж боломжгүй нь дайнд ойр дотнынхоо хүмүүсийг алдсан өөрийн болон найз нөхдийнхөө уй гашуудлыг цаг хугацаа өнгөрсөн ч насан туршдаа хүмүүс мартдаггүй, ой тойндоо хадгалж байдагтай холбоотой юм. Харин нийгэм, нийтээрээ амьдралд тохиолдсон гамшиг, гачигдал, тухайлбал дайны гамшигийг мартаж нь цөөнгүй байна. Дэлхийн II дайны хөлд нэрвэгдсэн хүмүүсийн сэтгэлийн шаналал, зовлонг мартаж нь ёс суртахууны хувьд хүн хүндээ нөхөр байхын утга учрыг алдсан “хоёр нүүрт” явдал, “бүдүүлэг” хэрэг болно. Үүнийг дараах хоёр баримтад тулгуурлан тайлбарлая.

Нэгд, мартаж байгаа учраас дайн үүсэх нөхцөлийг бүрдүүлэгчид, дайныг үргэлжлүүлэхийг хүсэгчид, цэрэг стратегийн хурцадмал байдлыг багасгахыг үл хүсэгчид олширчээ. Өнөөгийн Украины Ерөнхийлөгч Зелинсий, ЕХ болон НАТО-гийн гишүүн зарим улсуудын удирдлагын Украин дахь дайныг дэмжиж буй байдал, гэрээ хэлэлцээрт хандаж буй нь үүнийг харуулж байна. Мартаагүй ч түүнийг өөрсдийн ашиг сонирхлоос доогуур тавьж, дайныг үргэлжлүүлэхийг хүсэж байна. Тухайлбал, Их Британи – ОХУ-ын эсрэг эвслийн гол “тоглогч” болж, геополитик дахь өөрийн ашиг сонирхлыг хамгаалж, ОХУ-ын цэргийн хүч чадавхыг шавхахыг зорьж, Украин дахь дайныг “төлөөллийн дайн”-ы хэлбэртэй болгож байна. Их Британийн цэргийн дарга нар Оросын эсрэг эвслийн “тархи” болж операц, байлдааны ажиллагаанд оролцож байна. Украинд зааварлагч дарга нараа Их Британи илгээхээс гадна олон шинжээчдийн төсөөлж байснаас ч илүү үүрэг гүйцэтгэсээр байна. ***Хоёрт***, Украины олон нийт, нийгмээрээ ардчилал, хүний эрхээр хаацалсан, оросыг үзнэ ядах үзэл, үндсэрхэг үзлээр “тархиа угаалгаж”, эх орноо хамгаалах тэмцэл нь ямар ч үнээр хамаагүй болтлоо үргэлжилж, утга учраа алдаж, дэмжигч их гүрэн, эвслийн төлөө тэмцэгч болж “төлөөллийн дайн” явуулдаг болсон явдал нь дайныг зогсоохгүйд хүргэлээ. ***Гуравт***, ЕХ одоо үүнд бас голлон “тоглогч” боллоо. ЕХ-ны удирдлага АНУ-ын ивээлээс салахгүйн тулд

түүнд үнэнчээ илэрхийлэхийн тулд геополитикийн сөргөлдөөнд оролцогч болж, байгаа бүхнээ түүнд зориулж, өөрийн эдийн засгаа уналтад ортол дампуурч байна. ЕХ, НАТО-гийн өнөөгийн удирдлага оросын эсрэг үзэлтнээр дүүрч, дайныг зогсоох ямар ч санаачилга гаргахгүй, харин эсрэгээр ажиллаж байна. Тэдний бодит нүүр царай олон улсад танигдаад байна. Дөрөвт, Орос, Украины дайныг зогсоох хэлэлцээр хийх болзол болгож, фронт дахь байлдааны ажиллагааг бүрэн зогсоох асуудлыг барууныхан илэрхийлдэг байсан. Одоо үүнээсээ ухарсан нь тэрхүү болзол нь худал хуурмаг, үндэслэлгүй болохыг нь харуулах боллоо. Барууны орнууд Оросын эсрэг эдийн засаг, санхүүгийн салбарт чиглэсэн хориг арга хэмжээг “бодлогын гол хэрэгсэл” болгож байна. Зорилго нь ОХУ-ын дайныг үргэлжлүүлэх боломжийг хязгаарлаж, хэлэлцээрийн ширээний ард шахах явдал гэгцгээж байв. Мөн Украинд зэвсэг, сум нийлүүлж, өөрийн цэргийн мэргэжилтнүүдийг илгээж, өөрийгөө хамгаалахын зэрэгцээ, ОХУ-ыг зорилгоосоо татгалзахад хүргэнэ гэж үзэж байв. Барууны орнууд дайны талаарх баримтуудыг гуйвуулж, Оросын талаарх ташаа мэдээлэл, суртал ухуулгыг идэвхтэй явуулж байна.

Барууны орнууд энхийн замаар дайныг зогсоохын тулд дипломат хэлэлцээрийг хайхын оронд хамтын хүчин чармайлтаар түүнийг үргэлжлүүлэх бодлого баримталж байна. ОХУ-д энх тайвныг тогтоох ямар ч тодорхой санаачилга дэвшүүлээгүй, саад бэрхшээлийг арилгах арга замаа олохгүй, “хүчирхийллийг хүчирхийллээр шийдэх” талдаа байна.

Оросын тал, гал зогсоох хүсэлгүй байна гэж барууныхан үздэг. Цэргийн ажиллагааг зогсоохыг хүссэн шинж тэмдэг түүнд алга гэдэг. Тиймээс Орост үзүүлэх АНУ, ЕХ-ны шахалт нь жинхэнэ энхийн хэлэлцээний урьдчилсан нөхцөл болно хэмээдэг. Энэ нь бүтэшгүй бодлого болохыг бодит байдал харуулсаар байна.

Одоо урт хугацааны энх тайван байдлыг тогтоох, Орос улсын талын анхны Истанбулын хэлэлцээрийг харгалзах, гэхдээ цэргийн ажиллагааны орон зай дахь бодит байдалд үндэслэн энх тайвныг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байна гэсэн саналыг хүлээн авахад хүрч байна.

Одоогийн байдлаар олон нийтэд зарласан байр суурь: “денацификация (неонацист/бандера үзэл суртлыг хориглох), цэрэггүйжүүлэх (Украины зэвсэгт хүчнийг цөөлөх, энхийн үеийн цөөн тооны арми болгон өөрчлөх, зэвсэг, техникийг багасгах, алсын зайн зэвсэг, техникийг багасгах), орос хэл, соёлтой иргэдийн амь насыг олноор ахин бүрэлгүүлэхгүй байхын тулд оросын цэргийн эзлэн авсан нутгийг ОХУ өөрийн мэдэлд авч, үүний оронд Украинд урт удаан хугацааны энх тайван байдлыг баталгаажуулж өгөх гэсэн байр суурьтай болох төлөвтэй байна. Үүнийг нь АНУ-ын Ерөнхийлөгч Трамп дэмжиж байна.

Барууны орнууд Оросын түрэмгийллийг буруушааж, олон улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг баталгаажуулахын тулд НҮБ зэрэг олон улсын байгууллагуудыг ашиглаж байна.

Гурав. Дэлхийн II дайны төгсгөл: Чөлөөлөх дайны үр дагавар, ач холбогдлыг өргөн хүрээгээр ойлгох нь.

Энэ дайны сургамжаар гадаад, дотоодын олон эрдэмтэнд эрдэм шинжилгээний

өгүүлэл, илтгэл нийтүүлсэн байдаг. Тэдгээрийн дотор Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үе үеийн эрдэмтдийн илтгэлүүд дорвитой байр суурийг эзэлдэг. Эдгээр илтгэлүүдийг энэ онд тэмдэглэж буй ялалтын 80 жилийн ойд зориулан эмхэтгэж гаргасан юм⁵.

Гадаад дотоодын эрдэмтдийн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийг судалж үзэхэд, тэд “түүх бол агуу их багш” гэдэг үүднээс цаг үетэйгээ нийцүүлэн түүний сургамжийг авч үзсээр иржээ. Энэ дайны сургамжийг бид авч үзэхдээ: **нэгд**, тухайн цаг үеийн нөхцөл байдалтай холбон авч үзэж иржээ; **хоёрт**, сургамжийн ямар асуудлыг, аль өнцгөөс авч үзэх нь тухайн үеийн тулгамдсан асуудалтай холбоотой байжээ; **гуравт**, чөлөөлөх дайны ялалтын түүхэн ач холбогдлыг бид бүхэн Монгол Улсын тусгаар тогтнолтой холбон авч үзсээр иржээ

Дэлхийн II дайны үр дагавраар: **нэгд**, Гитлерийн эсрэг эвсэл ялалт байгуулж, Герман, Япон бууж өгснөөр Герман хэмээх улс төрийн төрийн байгуулал, нутаг дэвсгэрээ ялагч улсуудын эрх ашгийн дагуу хэд хэд хуваалгаж мөнхийн ялагдал хүлээв. **Хоёрт**, фашистын Германы холбоотон Итали улс колонио Ливи, Эритрей, Сомали, түүнчлэн 1930-аад онд эзэлсэн Этиоп, Албани зэрэг улсуудаа алдсан бол Япон улс Хятадад өрнүүлсэн найман жилийн дайн, Номхон далай дахь дөрвөн жил үргэлжилсэн дайнд ялагдаж, эзлэн авсан Хятадын зүүн хойд хэсэг Манжуураа, 1910 оноос эзлэн эрхшээсэн Солонгосоо алдаж, 1945 оны 9-р сарын 2-нд Америкийн байлдааны Миссури хөлөг онгоц дээр АНУ, ЗХУ зэрэг холбоотны гүрнүүдийн төлөөлөгчдөд Японы бууж өгөх баримт бичигт гарын үсэг зурав. **Гуравт**, Германы “тэнхлэг”-ийн эвслийг ялсан хэдий ч Гитлерийн эсрэг эвслийн орнуудын хоорондын санал зөрөлдөөн улам бүр нэмэгдэв. Их Британи, Франц, түүнчлэн АНУ оролцож НАТО-гийн цэргийн эвсэл байгуулж, хариуд нь социалист системд нэгдсэн Европын улсууд “Варшавын гэрээ”-г байгуулав. Ийнхүү дэлхийн II дайн дууссаны дараа “Хүйтэн дайн”-ы эрин эхэлсэн юм. Коммунизмыг дэмжигчид болон капитализм ба либерал ардчилсан хөгжлийн замыг дэмжигчид гэж дэлхийн улс орнууд хуваагдсан түүх саяхных. Үүний дагуу ЗХУ, АНУ гэсэн хоёр их гүрэн туйлуудыг тэргүүлж эхэлсэн юм. ЗХУ, АНУ нь дэлхийд эзлэх байр суурийг дэлхийн II дайнаар бэхжүүлсэний зэрэгцээ ЗХУ-ын хувьд, хил хязгаарыг өргөжүүлсэн явдал байв. Хойд талаараа Печенга, Кенигсберг, Клайпеда мужууд, Закарпат, Сахалин арлын өмнөд хэсэг, Курилын арлуудыг олж авсан⁶ юм. **Дөрөвт**, фашизм ба нацизмын үзэл суртлыг буруушааж, цаашид хориглох олон улсын механизм байгуулах үүднээс Нэгдсэн Үндэстний Байгууллагыг байгуулав. Гэсэн хэдий ч дэлхийн II дайн дууссаны дараа бүс нутгийн болон орон нутгийн дайн, мөргөлдөөн зогсоогүй бөгөөд тэдгээрийг энхийн замаар шийдвэрлэхийг уриалсан НҮБ хичээл, оролдлого олон улсын хурцадмал байдлыг намжааж чадахгүй байна. **Тавд**, өнөө үед дэлхийн II дайны үр дагавраар бий болсон хоёр туйлт систем задарч, ЗХУ, Югослав, Зүүн Герман, Чехословак, Османы эзэнт гүрэн зэрэг улс

⁵ Дэлхийн II дайны төгсгөл: чөлөөлөх дайн 1945 онб (эрдэм шинжилгээний хурлуудын эмхэтгэл). УБ., “Соёмбо принтинг” ХХК. 2025 он. -344х; ISBN 978-9919-9182-3-1;

⁶ Купцов В.П. Вторая мировая война: политические уроки. Вестник российского экономического университета им. Г.В. Плеханова.- 2015.-№3. С. 109-117.

орнууд байхгүй болж, нэг туйлт ба олон туйлт ертөнцийн төлөөх геополитикийн өрсөлдөөн явагдах боллоо. *Зургаад*, цус асгаруулсан халуун дайны хажуугаар “цусгүй дайн” өрнөж, цэргийн хүч хэрэгсэлд дулдуйдсан цэргийн бус (иргэний) хүч хэрэгслээр явагддаг шинэ маягийн “хосолмол” (гибридная война, hybrid war) дайн явагддаг боллоо.

Энэ бүхнээс харахад, дэлхийн II дайны үр дагавар, сургамжийг дэлхийн улс гүрнүүд, хүн төрөлхтөн аваагүй, ухамсарлаагүй өдий хүрчээ. Би үүнийгээ дэлхийн II дайны үйл явдлын талаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины саяхан нийтүүлсэн өгүүллээс эш татаж бататгая. “Тэргүүлэх бүх гүрнүүд дэлхийн II дайн эхэлсэнд аль нэг хэмжээгээр буруутай, ... харалган зан гаргаж, хамтын аюулгүй байдлын систем бүтээхээс татгалзсанаа төлөөсийг бид сая сая хүний амь нас, асар их гарз хохирлоор төлсөн билээ. ... Бидний хэнд ч гэсэн үнэн хийгээд бодит байдал хэрэгтэй байна. ..., тэр үед гаргасан алдааг давтахгүй байх, энхийн болон сайн сайхан хөгжлийг олон жилийн өмнөөс хангахад нэн чухал байна. Гэвч манай олон хамтрагчид энэ хамтын ажилд одоохондоо бэлэн бус байна”⁷ гэсэн байна.

Өнөөдөр болж буй улс төрийн тэмцэл ямар төлөв байдалд байгааг дурдах нь аюулыг ойлгох, ухамсарлахад ач тустай хэмээн үзэж байна. Энэ нь дайн хэмээх уламжлалт аюулаас гадна уламжлал бус аюулын төрөл, хэлбэр олширч, улс гүрэн, ерөөс хүн төрөлхтөн орших, эс оршиход эргэлзээ төрүүлэхэд хүргэж болзошгүй болжээ.

Геополитикийн ямар ч үзэл баримтлал ялгаагүй, тэрхүү геополитикийг явуулагч гүрэн эзэмшлийн болон нөлөөний орон зай (эх газар, далай тэнгис, агаар, сансар, кибер)-гаа тэлэх, зах зээлийг булаан эзэмших, хадгалах зорилгоор улс төр, эдийн засаг хүн ам, мэдээлэл, үзэл суртал, шилдэг технологийн болон цэргийн хүчирхийллийн арга хэрэглэх бодлого, стратеги болно.

Геополитикийг дэлхийн хүчирхэг гүрнүүд явуулж, бусад улс гүрнүүд байнгын, түр, үл оролцогч байдлаар татагддаг байна. “Геополитикийн тэмцлийн талбарт тэмцэл явуулагч улсын тоо гарын арван хурууны тооноос хэтэрсэнгүй”⁸ нь нэгд, улстөрийн бодлого байнгын нь асар хүчтэй явагддагт; **хоёрт**, их гүрний статусыг олон жил хадгалж ирсэн түүхэн чадварт; **гуравт**, эх газар, эх далай тэнгисийг эзэмших, хадгалах, хамгаалах цэргийн чадвар зэрэг шинж чанартай нь холбоотой байна. Геополитикийн бодлого, стратегийг тодорхойлогч улс биш ч, түүнд өртөгдөх магадлал өндөртэй улс орон хувь заяаны төөргөөр геополитикт оролцогч болдог жамтай байна. Үүний нэг нь Монгол Улс юм.

Монгол Улс геополитикийг явуулагч субъект биш юм. “Монголын геополитик” гэсэн үг хэллэг нь геополитикийн нөхцөлд Монгол Улс хэрхэн орших тухай асуудлыг хөндөж буй судлаачдын үзэл санаа юм.

Өнөө үед геополитик бол цэвэр цэрэг, улс төр, газар зүйн хүрээний асуудлаасаа хальж, нийгэм, эдийн засаг, мэдээллийн болон кибер орон зай, байгаль, нийгмийн

⁷ В.Путин. “Агуу их Ялалтын 75 жил: түүх хийгээд ирээдүйн өмнө хүлээх нийтлэг хариуцлага”. *Sonin.mn agency*. 2020.06.22;

⁸ Стариков Н.В. *Геополитика. Как это делается*. Издательство, Питер. 2017. – 368с. ISBN, 978-5-4461-0456-7;

жам ёсны олон соёл иргэншлийн үйл явцаар илэрхийлэгдэх ээдрээ төвөгтэй олон асуудлыг хүн төрөлхтний өмнө босгон тавиад байна.

Дэлхийн геополитикийн нөхцөл байдал нь дэлхийн их гүрэн болон бүс нутгийн их гүрнүүдийн үндэсний аюулгүй байдлын стратегийн чиглэлээр улс төрийн шийдвэр гаргахад хүчтэй нөлөө үзүүлсээр байна. Геополитикоор их гүрнүүдийн үндэсний аюулгүй байдлаа хангах, ашиг сонирхлоо хамгаалах стратеги нь уламжлалт дайн биш болж уламжлалт бус дайн, хосолмол дайн болжээ.

Өнөөдөр дайны аюул өсөхийн хэрээр шинжлэх ухаан, технологийн хөгжлийн үр дүнг зэвсэгт мөргөлдөөнд ашиглах нь хүчтэй болж байна. Радар, тийрэлтэт онгоц, баллистик пуужин, антибиотик, компьютер, робот, нисэгчгүй нисэх төхөөрөмж болон бусад олон шинэ бүтээл, нээлтүүд өргөн хэрэглэгдэж байна. ХХ зууныг ихэвчлэн атомын эрин гэж нэрлэдэг атомын энергийг эзэмших эхлэл нь дайнаас улбаатай байдаг. Тэр үед шинжлэх ухаан, технологийн хувьсгалын үндэс тавигдсан бөгөөд энэ нь дайны дараах ертөнцийг өөрчилсөн бөгөөд одоо ч өөрчлөгдсөөр байна. Хүн төрөлхтөн энэ дайнаас хойш атомын зэвсгийн аюулын айдас доор амьдарч эхэлсэн, одоо ч хэвээрээ байна. “Атомын цахилгаан станц бол цахилгаан үйлдвэрлэдэг атомын бөмбөг юм” гэсэн үгийг одоо, олон жилийн дараа цөмийн бус мэргэжилтнүүд ч гэсэн ойлгодог болжээ. 100 Мт-ын цөмийн зэвсгийн дэлбэрэлт болсон тохиолдолд бүрэн сүйрлийн бүс нь 35 км орчим радиустай байх бөгөөд 50 км-ийн радиуст хүчтэй сүйрэл мэдрэгдэнэ. Дэлбэрэлтийн голомтоос 80 км-ийн зайд байгаа хүмүүс гуравдугаар зэргийн түлэгдэлт авч болзошгүй. 100 Мт-ын цөмийн зэвсгийн нэг дэлбэрэлт нь дэлхийн аль ч том хотыг бүрэн сүйрүүлэх чадвартай ажээ. Ийм хүчин чадалтай атомын бөмбөг нэг биш хэдэн мянгаар зэвсгийн санд хадгалагдаж байна.

Дайныг олон талаас нь судалж болно, гэвч судалгааны гол агуулга, мөн чанар нь “дайн” хэмээх нийгмийн аюулаас ангид оршуулах ухаарлыг хүн төрөлхтний оюун санаанд суулгах, дахин дайн гаргуулахгүй байхын тулд урьдчилан сэргийлүүлэх, олон талт арга хэмжээ авч ёс суртахуунтай байлгахад оршино.

Бид Дэлхийн II дайны төгсгөл: Чөлөөлөх дайны сургамжийг судлахдаа дэлхий дахинаа амар амгалан байхад монгол түмэн хувь нэмрээ оруулж байхын төлөө эд баялгаараа биш, эрдэм ухаан, мэдлэг, ёс суртахуунаараа дэмжлэг үзүүлэхийн төлөөнөө гол зорилгоо чиглүүлдэг. Тийм ч учраас дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд Монгол Улсын оруулж ирсэн хувь нэмрийг улам өсгөх, үндэсний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд гадаад харилцааг өргөтгөн хөгжүүлж, түүний үр өгөөжийг улам нэмэгдүүлэх шаардлага тулгарч байгааг тэмдэглэдэг юм.

Дайны сургамжийг харгалзаж, эмгэнэлт явдал давтагдахаас сэргийлж, энх тайвныг сахин хамгаалж, хүмүүнлэгийн үнэт зүйлсийг сурталчлахад чиглүүлж иржээ. Энэ дайны сургамж нь эх оронч сэтгэлгээг хөгжүүлэх, энх тайвны үнэ цэнийг ойлгуулах, цэргийн мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх шийдэмгий байдлыг бэхжүүлэхэд тусалдаг. Өнөөдөр бид энэ дайны сургамжийг ирээдүйтэйгээ холбон үзэж, түүний агуулгыг шинэлэг байдлаар, судалгаа шинжилгээнийхээ ажилтай холбон инновацлах тал руу хандуулах нь чухал хэмээн үзэж байна.

Судлаачдын хувьд, дайны сургамжийг харгалзан үзэх шаардлагатай хэд хэдэн хүчин зүйл байдаг. **Нэгд**, дайны шалтгаан, үр дагаварт дүн шинжилгээ хийх, өмнөх цэргийн мөргөлдөөний туршлагыг судлах нь шинэ дайнаас урьдчилан сэргийлэх механизмыг хөгжүүлэх, дипломат харилцаа, маргааныг тайван замаар шийдвэрлэхэд тусална. **Хоёрт**, дайны сургамжийн судалгаа нь милитаризм, түрэмгийлэл юунд хүргэдгийг баримтад тулгуурлан илэрхийлж, олон нийтэд итгэл үнэмшлийг төрүүлэхэд чиглэнэ. Тэдэнд энх тайвныг сахин хамгаалах, олон улсын харилцаа, улс хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн чухлыг сануулна. **Гуравт**, дайны зовлон зүдгүүр, хохирогчдын тухай, хорон мууг эсэргүүцсэн хүмүүсийн баатарлаг байдал, эр зоригийн тухай дурсамжийг мөн баримтад тулгуурлан илэрхийлж, залуу хойч үедээ энэрэн нигүүлсэх, хүний амь насыг хүндэтгэх, хүчирхийллийг үгүйсгэх сэтгэлийг төлөвшүүлэх хүмүүнлэгийн үнэт зүйлсийг хөгжүүлэхэд тусална. **Дөрөвт**, дайнд оролцогсдын дурсамжийг судлах нь судалгааныхаа үр дүнг бататгахын зэрэгцээ, үндэсний түүх, соёлын нэг хэсгийг бүтээж буй хэрэг юм. Энэ нь түүхэн үнэнийг хадгалах, өнгөрсөн үеийн туршлагыг хойч үедээ таниулах, бахархах сэтгэлийг төрүүлэх, тэдний баатарлаг, эх оронч үйл хэргийг өвлүүлэх, үндэсний онцлогийг бэхжүүлэхэд тусална. **Эцэст онцлоход**, дайны сургамжийн судалгаа нь улс орноо батлан хамгаалах бодлогоо шинжлэх, боловсруулах, батлан хамгаалах, аюулгүй байдлын тогтолцоог сайжруулах, гадаад, дотоодоос үүсэх түрэмгийллээс хамгаалах шинэ стратеги боловсруулах боломжийг бидэнд олгоно.

Ийнхүү дайны сургамжийн судалгаа нь энх тайван, аюулгүй, чинээлэг ирээдүйг бий болгоход зайлшгүй шаардлагатай. Дайны тухай дурсамж нь хүмүүнлэг, шударга нийгмийг хөгжүүлэх сэрэмжлүүлэг, хөшүүрэг байх ёстой болж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. МУУТА.ТБА. Х-1, Д-3, ХН-401.х12-13;
2. Үндэсний статистикийн хороо. Монгол Улсын хүн ам – 1923. УБ., 2024 он. Т.4;
3. Д. Гомбосүрэн. Монгол Ардын Хувьсгалт Цэргийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулсан нь. Чөлөөлөх дайны 55 жилийн ойн олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. 2000 он;
4. Г.Мягмарсамбуу. 78 - 80-аад хүн дайнд нас барсан, сураггүй болсон буюу шархадсан байна. 122 хүн амь насаа алдсан гэж Ю.Цэдэнбал даргын хүн хүчний хохирлыг гаргасан тоо;
5. Дэлхийн II дайны төгсгөл: чөлөөлөх дайн 1945 онб (эрдэм шинжилгээний хурлуудын эмхэтгэл). УБ., “Соёмбо принтинг” ХХК. 2025 он. -344х; ISBN 978-9919-9182-3-1;
6. Купцов В.П. Вторая мировая война: политические уроки. Вестник российского экономического университета им. Г.В. Плеханова.- 2015.-№3. С. 109-117.
7. В.Путин. “Агуу их Ялалтын 75 жил: түүх хийгээд ирээдүйн өмнө хүлээх нийтлэг хариуцлага”. Sonin.mn agency. 2020.06.22;
8. Стариков Н.В. Геополитика. Как это делается. Издательство, Питер. 2017. – 368с. ISBN, 978-5-4461-0456-7;